



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/07

Жавхлант

Эд хөрөнгийг бүртгэлжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.6, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1.3, 2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан “Малын вакцин хадгалах хөргүүр” -ийг 9800000 (есөн сая найман зуун мянга) төгрөгөөр төрийн байгууллагын өмчид бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Оюунчимэг), нягтлан бодогч (С.Наранцэцэг) нарт даалгасугай.

2. Төрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн хүрээнд үнэлж бүртгэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Т.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН